

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЗАХИАЛГАТ АУДИТ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ӨМА-2023/42-ШТА-ГА

ДҮГНЭЛТ: АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ХИЙСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР
ӨГӨӨЖИЙГ ТООЦОЖ БАЙХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Даланзадгад хот 2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Шижирболд
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn
Аудитор Э.Бат-Эрдэнэ
Утас: 70533552 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу: Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгт, график, зургийн жагсаалт	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	3
Ерөнхий мэдээлэл.....	4
БҮЛЭГ 1. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДТЭЙ НИЙЦСЭН БАЙНА.....	6
А.1 Төсөл арга хэмжээ урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.	6
А.2 Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуульд нийцүүлж төлөвлөсөн байна.	8
БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АШИГЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	9
Б.1 Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан байна.....	9
Б.2 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.....	9
Б.3 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт хийгдээгүй байна.	14
Б.4 Төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, бүртгэлийг сайжруулах шаардлагатай байна.....	15
ДҮГНЭЛТ	16
ЗӨВЛӨМЖ.....	17
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	18
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	19

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
ХШҮДАХ	Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ЗҮГСШЖ	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах журам
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ШТА	Шууд тайлагнах аудит
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БОХЧХ	Байгаль орчныг хамгаалах чиглэлийн хөрөнгө
ТАХ	Төсөл арга хэмжээ
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар

ХҮСНЭГТ, ГРАФИК, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	ТАХ бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал	6
Хүснэгт 2	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ	8
Хүснэгт 3	ХАА-нд мөрдсөн журам төсөл, арга хэмжээний ангилал	9
Хүснэгт 4	Баталсан төсөл, арга хэмжээ	9
Хүснэгт 5	ТАХ-г хөрөнгөд бүртгэсэн байдал	15
График 1	Өмнөговь аймагт ирсэн жуулчдын тоо	5
График 2	Аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалт	7
Зураг 1	Хонгорын голын мэдээллийн төв, худалдаа үйлчилгээний барилга	11
Зураг 2	Шар цавын хээрийн лаборатори-музейн барилгын доторх фото зураг	12
Зураг 3	Дэмчигийн хийд, Нарны сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй гэрэлтүүлэг	13
Зураг 4	Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийг аялал жуулчлалтай хослуулан хамгаалах ажил	14

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/04 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-нд тусгасан дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилго

Аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтыг бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх
- Хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй байна уу

Хамарсан хүрээ

Аудитад Өмнөговь аймгийн ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 65 дугаар албан бичгээр ирүүлсэн сэдвийн саналын дагуу аялал жуулчлалын чиглэлээр 2020-2022 онд хэрэгжүүлсэн 20 төсөл арга хэмжээний төсөв болон бусад эх үүсвэрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан зэргийг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол улсын аудитын стандарт MNS 6817-5:2020, гүйцэтгэлийн аудитын зарчим MNS 6817-6:2020, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2020-2022 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- “Алсын хараа” 2050 Монгол Улсын урт хугацааны урт хугацааны хөгжлийн бодлого,
- Аймгийн ИТХ-ын 2020 оны 2/3 дугаар тогтоолоор баталсан “Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,
- Аймгийн ИТХ-ын 2020 оны 2/4 дугаар тогтоолоор баталсан “Өмнөговь аймгийг Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”,
- Аймгийн ИТХ-ын баталсан 2020-2022 оны төсөв, тодотгол,

- Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”
- Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Э.Бат-Эрдэнэ нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл

Аялал жуулчлалын тухай хуульд аялал жуулчлал гэж хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа өөр газарт 90 хоног хүртэлх хугацаагаар суралцах, ажил хөдөлмөр эрхлэхээс бусад зорилгоор аялан явахыг ойлгоно гэж тодорхойлжээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан. Хөгжлийн бодлогын Зорилт 8.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ” гэж тусгасан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/3 дугаар тогтоолоор “Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 2/4 дугаар тогтоолоор “Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг тус тус баталсан.

Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд аялал жуулчлалын талаар “Орон нутгийн онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ”, “Уул уурхайн салбарын орлогоор аймгийн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, шинжлэх ухаан технологи, тээвэр болон бусад секторыг дэмжиж эдийн засгийн олон тулгуур бүтэцтэй болгоно” гэж зорилт дэвшүүлсэн байна.


Өмнөговь аймагт аялал жуулчлалын салбарт 2020-2022 онд нийт 4,844.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 20 төсөл арга хэмжээг улс, орон нутаг болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсөл арга хэмжээний 40 хувийг барилга байгууламж, 10 хувийг тоног төхөөрөмж, 20 хувийг ТЭЗҮ, 30 хувийг бусад арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Өмнөговь аймгийн төв Даланзадгад хот Улаанбаатараас 585 км зайд далайн төвшнөөс дээш 1400 метрийн өндөрт оршдог. Өмнөговь аймаг хөгжлийн тэргүүлэх салбараа Хариуцлагатай уул уурхай, Тогтвортой аялал жуулчлал, Эрчимжсэн болон уламжлалт мал аж ахуйн салбар хэмээн тодорхойлсон байна.

Өмнөговь аймагт 26 жуулчны бааз, 18 зочид буудал, 47 гэр буудал, 45 дэн буудал, 8 кофе шоп, 4 амралтын газар, 35 тэмээ, 23 морь унуулах үйлчилгээ үзүүлдэг иргэд, 51 гар урлал, бэлэг дурсгалын зүйл зарж борлуулдаг иргэд, 41 жуулчин тээврийн жолооч байнга болон улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээр хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдийн аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг нэгтгэн тооцох боломжгүй байна.

График 1: Өмнөговь аймагт ирсэн жуулчдын тоо



Эх сурвалж: Аймгийн БОАЖ-ын газар

Өмнөговь аймгийн хамгийн үзэсгэлэнтэй, байгалийн чухал хэв шинжүүд, ховор амьтан, ургамал, шувууд, тэдгээрийн амьдрах орчин бүхий Ханхонгор, Хүрмэн, Баяндалай, Сэврэй, Гурвантэс, Булган сумдын нутаг дэвсгэрүүдийг хамарсан нийт 2694.3 мянган га талбайг 1993 онд УИХ-ын 83-р тогтоолоор Улсын тусгай хамгаалалтад авсан.

Үүнээс гадна Говийн бага дархан газраар Номгон, Баян-Овоо, Ханбогд сумд Дорноговь аймгийн Хатанбулаг сумын өмнөд хэсгийн хилийн заагийг хамарсан 1,830,429 га газрыг 1996 оны УИХ-ын 43 дугаар тогтоолоор дархан газар болгожээ.

БҮЛЭГ 1. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДТЭЙ НИЙЦСЭН БАЙНА.

А.1 Төсөл арга хэмжээ урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

1.1 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аялал жуулчлалын салбарт 2020-2022 онуудад 8 барилга байгууламжид 3,363.3 сая төгрөг, 2 тоног төхөөрөмжид 425.5 сая төгрөг, 4 техник, эдийн засгийн үндэслэлд 190.0 сая төгрөг, зардлын шинж чанартай 6 төсөл, арга хэмжээд 866.0 сая төгрөг зарцуулахаар тус тус баталсан байна.

1.2 Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Уул уурхайн салбарын орлогоор аймгийн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, шинжлэх ухаан технологи, тээвэр болон бусад секторыг дэмжиж эдийн засгийн олон тулгуур бүтэцтэй болгоно” гэсэн зорилт дэвшүүлсэн байна .

1.3 Мөн Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд хөгжлийн тэргүүлэх 8 салбарын нэг бол “Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэх замаар эдийн засгийн тогтвортой хөгжлийн салбах болгон хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн жуулчдын тоог нэмэгдүүлнэ” гэж тодорхойлжээ.

1.4 Аялал жуулчлалын салбарт 2020-2022 онд хийхээр төлөвлөсөн 4,844.8 сая төгрөгийн төсөвтэй 20 төсөл арга хэмжээ нь Алсын хараа-2050, Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн байна.

Хүснэгт 1: ТАХ бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал

Д/д	ТАХ-ий ангилал	2020-2022 оны төлөвлөлт				Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй	
		ТАХ-ний тоо	Эзлэх хувь	Төлөвлөгөө (сая төгрөг)	Эзлэх хувь	Нийцсэн ТАХ-ны тоо	Нийцээгүй ТАХ-ны тоо
1	Барилга байгууламж	8	40	3,363.30	69.4	8	-
2	Их засвар	-	-	-	-	-	-
3	Тоног төхөөрөмж	2	10	425.5	8.8	2	-
4	ТЭЗҮ	4	20	190	3.9	4	-
5	Бусад	6	30	866	17.9	6	-
Дүн		20	100	4,844.80	100	20	-

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

1.5 Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар дэвшүүлсэн зорилтуудыг хангах чиглэлээр тусгасан зарим томоохон ажлуудыг хийж эхлээгүй байгаа нь цаг хугацааны хувьд хэрэгжих боломжгүй болох эрсдэлтэй байна. Үүнд:

- Өмнөговь аймгийн аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөгөөний дагуу аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэн иргэд, малчид, бизнес эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ,
- Уул уурхайн салбарын орлогоор аймгийн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, шинжлэх ухаан технологи, тээвэр болон бусад секторыг дэмжиж эдийн засгийн олон тулгуур бүтэцтэй болгоно,

- “Даланзадгайн цэцэрлэгт хүрээлэн” иж бүрэн төслийг орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлан Даланзадгад сумын аялал жуулчлалын гол зорих газар болгон үе шаттайгаар хэрэгжүүлнэ,
- Бүс нутгийн аялал жуулчлалын хамтын ажиллагаанд нэгдэх бодлого хэрэгжүүлнэ.


1.6 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/10 дугаар тогтоолоор “Аялал, жуулчлалыг хөгжүүлэх хэтийн зорилго, төлөвлөгөө (2019-2029 он)”-г баталсан байна.

1.7 Тус тогтоолд менежментийн төлөвлөгөөнүүдийг шат дараатай боловсруулан, шаардагдах хөрөнгийг жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусган хэрэгжүүлж, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасан боловч 2020-2022 онд тайлагнаагүй байна.

1.8 Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хэрэгжилтэд 2023 оны эхний хагас жилд хийсэн аймгийн Хяналт шинжилгээ, үнэлгээний тайланд зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдвэрлээгүй хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэсэн байна.

1.9 Аялал жуулчлалын салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтыг сүүлийн 3 жилийн байдлаар голлох салбаруудтай харьцуулахад 2-13 дахин бага байна.

График 2: Аймгийн хэмжээнд хийсэн хөрөнгө оруулалт судалгаа



Эх сурвалж: Аудитын ажлын баримт

1.10 Энэ нь аялал жуулчлалын салбарт хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг нэмэгдүүлэх, үр дүнг тооцон тайлагнаж байх шаардлагатайг харуулж байна.

А.2 Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуульд нийцүүлж төлөвлөсөн байна.

2.1 Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹, 68 дугаар зүйлийн 68.2²-т хөрөнгө оруулалт гэдгийг тодорхойлж, ямар шаардлага хангасан төсөл арга хэмжээг төсөвт тусгахыг заасан байдаг.

2.2 Жил бүр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлэн жагсаалтыг аймгийн Засаг даргаас Сангийн яамд албан бичгээр улсын төсвийн хөрөнгөөр хийлгэх саналыг хүргүүлсэн байна.

2.3 Дэмжигдээгүй төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх саналаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж батлуулсан байна. Аялал жуулчлалын салбарт 2020-2022 онд хийхээр төлөвлөсөн 4,844.8 сая төгрөгийн төсөвтэй 20 төсөл арга хэмжээг дээрх он оны жагсаалтад тусган батлуулсан байна.

2.4 Аялал жуулчлалын салбарт 2020-2022 онд хийхээр төлөвлөсөн 4,844.8 сая төгрөгийн төсөвтэй 20 төсөл арга хэмжээний хувьд техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөвтэй төсөл, арга хэмжээ батлуулсан байна.

2.5 Тус жагсаалтад 866.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 6 төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.Үүнд:

Хүснэгт 2: Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ

№	Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр	Баталсан он	Баталсан төсөв /сая төгрөг/	Эх үүсвэр
1	"Аялал жуулчлал-Өрхийн орлого" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, эвент арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах /усны төлбөрийн орлогоос/	2020	105.0	Орон нутгийн төсвийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээ
2	"Аялал жуулчлалыг хөгжүүлэх хэтийн зорилт, төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх, орон нутгийн эвентүүд болон сургалт, зөвлөгөөн зохион байгуулах /усны төлбөрийн орлогоос/	2021	50.0	ОНТ-ийн байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгөөр
3	Буга нутагшуулах, тоо толгойг нэмэгдүүлэх, "Говийн гайхамшигт зургаа" уулзалт арга хэмжээг Өмнөговь аймагт зохион байгуулах /усны төлбөрийн орлогоос/	2021	90.0	ОНТ-ийн байгаль орчныг хамгаалах чиглэлийн хөрөнгөөр
4	Өмнөговь аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хэтийн зорилт, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, орон нутгийн эвентүүдийг хөгжүүлэх, аялал жуулчлалын үзэсгэлэн, уулзалт, зөвлөгөөн, сургалтад оролцох, зохион байгуулах	2022	404.5	ОНТ-ийн байгаль орчныг хамгаалах чиглэлийн хөрөнгөөр
5	Түүх соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, олон нийтэд сурталчлан таниулах, сургалт танин мэдэхүйн ажлуудыг зохион байгуулах	2022	208.5	Орон нутгийн төсвийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээ
6	Аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	2022	8.0	Сумын төсвийн хөтөлбөр, ТАХ
Нийт			866.0	

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

2.6. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2³-т заасантай нийцэхгүй байгаа тул цаашид хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх шаардлагатай байна.

¹ "Хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг",

² "Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана."

³ "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АШИГЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Б.1 Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

1.1 Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны алба орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020-2022 онд хэрэгжихээр баталсан төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна.

1.2 Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгасан дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47⁴-д заасны дагуу шаардлагад нийцсэн 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

1.3 Худалдан авах ажиллагааны алба 7 ажилд нээлттэй, 1 ажилд харьцуулалт, 3 ажилд зөвлөх үйлчилгээний аргаар сонгон шалгаруулалт зарласан бол 7 ажилд шууд гэрээ байгуулсан байна. /Дэлгэрэнгүй судалгаа хавсаргав/

Хүснэгт 3: ХАА-нд мөрдсөн журам төсөл, арга хэмжээний ангилал

д/д	Ангилал	ХАА-нд мөрдөгдсөн журам			
		НТШ	Харьцуулалтын арга	ЗҮГСШЖ	Шууд худалдан авах
1	Барилга байгууламж	6	1	-	1
2	Их засвар	-	-	-	-
3	Тоног төхөөрөмж	1	-	-	-
4	ТЭЗҮ	-	-	3	-
5	Бусад	-	-	-	6
Дүн		7	1	3	7

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

1.4 Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороод нь тендерийн баримт бичгийг ТБОНӨХБАҮХАТХ болон Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу боловсруулан батлуулж, худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд мэдээлсэн байна.

1.5 Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй, цахим хэлбэрээр зохион байгуулсан ба худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол гараагүй байна.

Б.2 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

2.1 Төсвийн хөрөнгө оруулалтаар аялал жуулчлалын салбарт 2020-2022 онд 8 барилга байгууламжид 3,049.8 сая төгрөг, 1 тоног төхөөрөмжид 202.4 сая төгрөг, 3 техник, эдийн засгийн үндэслэлд 162.2 сая төгрөг, 6 бусад хөтөлбөр төсөл, эвент арга хэмжээнд 583.7 сая төгрөг нийт 18 төсөл, арга хэмжээнд 3,998.1 сая төгрөгийн санхүүжилтийг баталгаажуулсан гүйцэтгэлийг үндэслэн олгосон байна.

⁴ Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орсон албан тушаалтан дараах шаардлагыг хангасан байвал зохино

Хүснэгт 4: Баталсан төсөл, арга хэмжээ

/сая.төгрөг/

№	Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр	Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Хэрэгжүүлэх хугацаа		Баталсан дүн /сая төгрөг/	Гүйцэтгэл /сая төгрөг/
				эхлэх	дуусах		
1	Хонгорын голын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх /усны төлбөрийн орлогоос/	ОНТ-ийн БОХЧХ-өөр	Барилга байгууламж	2020	2020	200.0	197.5
2	Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийг аялал жуулчлалтай хослуулан хамгаалах	ОНТХО-аар	Барилга байгууламж	2020	2020	706.8	705.6
3	Баянзаг, Ёлын амны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	ОНТХО-аар	Барилга байгууламж	2020	2020	615.0	598.1
4	"Аялал жуулчлал-Өрхийн орлого" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, эвент арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах /усны төлбөрийн орлогоос/	ОНТ-ийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	Бусад	2020	2020	105.0	44.4
5	"Аялал жуулчлалыг хөгжүүлэх хэтийн зорилт, төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх, орон нутгийн эвентүүд болон сургалт, зөвлөгөөн зохион байгуулах /усны төлбөрийн орлогоос/	ОНТ-ийн БОХЧХ-өөр	Бусад	2021	2021	50.0	13.9
6	Хонгорын гол, Дэмчогийн хийдийг нарны сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт холбож, шар цавын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, тохижилт бүтээн байгуулалтыг хийх /усны төлбөрийн орлогоос/	ОНТ-ийн БОХЧХ-өөр	Барилга байгууламж	2021	2021	392.3	362.8
7	Буга нутагшуулах, тоо толгойг нэмэгдүүлэх, "Говийн гайхамшигт зургаа" уулзалт арга хэмжээг Өмнөговь аймагт зохион байгуулах /усны төлбөрийн орлогоос/	ОНТ-ийн БОХЧХ-өөр	Бусад	2021	2021	90.0	89.7
8	Ёлын аманд байрлах Байгалын Музейн цахилгааны шугамыг шинэчлэх	ОНТХО-аар	Барилга байгууламж	2021	2021	17.5	16.9
9	Аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө боловсруулах /Гурвантэс сум/	Сумын ОНХС	ТЭЗҮ	2021	2021	60.0	60.0
10	Ханбогд-Оюутолгой чиглэлийн хатуу хучилттай авто замаас Дэмчогийн хийд хүртэл хатуу хучилттай авто замын зураг төсөв боловсруулах	ОНХС	ТЭЗҮ	2022	2022	75.0	73.7
11	Ундны усны аюулгүй байдлын 2022 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд уст цэгийн бүртгэл тооллогыг хийж, ундны усны чанарыг сайжруулах, аялал жуулчлал, амралт сувиллын газруудын ус хангамж, бохир ус цэвэрлэгээний байдалд үнэлгээ өгч дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх	ОНТ-ийн БОХЧХ-өөр	Тоног төхөөрөмж	2022	2022	275.5	202.4
12	Өмнөговь аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хэтийн зорилт, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, орон нутгийн эвентүүдийг хөгжүүлэх, аялал жуулчлалын үзэсгэлэн, уулзалт, зөвлөгөөн, сургалтад оролцох, зохион байгуулах	ОНТ-ийн БОХЧХ-өөр	Бусад	2022	2022	404.5	268.3
13	Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, "Цайны зам" олон улсын аялал жуулчлалын холбооны үйл ажиллагаанд оролцох, мэдээллийн төв байгуулах ажлыг судалж шийдвэрлэх	ОНТ-ийн БОХЧХ-өөр	ТЭЗҮ	2022	2022	25.0	-

14	Хонгорын гол, Хэрмэн цав орчмын байгалийн үзэсгэлэнт газрын менежментийн төлөвлөгөөний тохижилтын ажлыг дуусгаж, Дэмчогийн хийд, Уртын амралтын менежментийн төлөвлөгөө боловсруулах, мэдээлэл үйлчилгээний төв байгуулах	ОНТ-ийн БОХЧХ-өөр	Барилга байгууламж	2022	2022	441.7	221.5
15	Баянзаийн нэвтрэх цэг болон мод үржүүлгийн талбайг батлагдсан зураг төсвийн дагуу ЦДАШ-д холбох	ОНТ-ийн БОХЧХ-өөр	Барилга байгууламж	2022	2022	790.0	749.7
16	Ханбогд-Оюутолгой чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаас Дэмчогийн хийд хүртэлх цахилгааны шугам татах зураг төсөл боловсруулах	ОНТХО-аар	ТЭЗҮ	2022	2022	30.0	28.5
17	Түүх соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, олон нийтэд сурталчлан таниулах, сургалт танин мэдэхүйн ажлуудыг зохион байгуулах	ОНТ-ийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	Бусад	2022	2022	208.5	159.4
18	"Эко жорлон" хөтөлбөрийг хэрэгжүүлж, Даланзадгад сумын гэр хорооллын айл өрх, аялал жуулчлалын түр буудаллах цэгүүдэд эко жорлон суурилуулах	ОНТ-ийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	Тоног төхөөрөмж	2022	2022	150.0	-
19	Аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /Сэврэй сум/	Сумын төсвийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	Бусад	2022	2022	8.0	8.0
20	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг	УТХО	Барилга байгууламж	2022	2022	200.0	197.7
Нийт						4,844.8	3,998.1

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

2.2 Батлагдсан төсөв нь төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар төлөвлөгөөнд тусгагдсан 2 ажил хийгдээгүй байна.

2.3 Аудитаар хийсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, ашиглалтын явцыг шалгахад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд 197.5 сая төгрөг, 2021 онд үргэлжлүүлэн 179.0 сая төгрөгөөр хийсэн хонгорын голын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мэдээллийн төвийн барилга, худалдаа үйлчилгээний барилгуудын ажлууд ажлын даалгаварт заасан хаяавч бетон цутгах ажил хийгдээгүй байна.

Зураг 1: Хонгорын голын мэдээллийн төв, худалдаа үйлчилгээний барилга



- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй 705.6 сая төгрөгийн өртөг бүхий Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийг аялал жуулчлалтай хослуулан хамгаалах ажлын хээрийн лаборатори-музейн барилгын зургийн даалгаварт туссан дараах ажил хийгдээгүй байна. Үүнд:

- Механик эргэлттэй агаар өгөх ба зайлуулах систем,
- Борооны усны систем,
- Гал унтраах усны шугам,
- Үүдний хэсэг болон коридорт мэдрэгчтэй гэрэл,
- Коридорт ослын тог баригчтай “гарах” тэмдэг бүхий гэрэл,
- Авто зогсоолд шалган нэвтрүүлэх хяналт тавих систем /хүний царай, автомашины номер таньж чадах нарийвчлалтай/,
- Гадна тохижилтын гэрэлтүүлэг

Зураг 2: Шар цавын хээрийн лаборатори-музейн барилгын доторх фото зураг



- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлсэн Хонгорын гол, Дэмчогийн хийдийг нарны сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт холбож, шар цавын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, тохижилт бүтээн байгуулалтыг хийх ажлын хүрээнд хийсэн Дэмчогийн хийдийг нарны сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт холбох 60.9 сая төгрөгийн өртөг бүхий ажлын гүйцэтгэл нь ажлын даалгаварт туссан тоо, хэмжээ хүчин чадалд хүрэхгүй, ажлын чанар, гүйцэтгэл хангалтгүй байна. Үүнд:

- Ажлын тоо хэмжээнд 12 ширхэг нарны хавтан туссанаас 3 ширхэг дутуу, суурийн бэхэлгээг чанаргүй гүйцэтгэсэн,
- Хадны гэрэлтүүлэгчийн цэнэг хураагуур болон дэлгэцийн бэхэлгээнд төмөр шон, бетон суурь цутгаж хийгээгүй,
- Туузан гэрлийн урт тоо хэмжээнд хүрээгүй, угсарсан гэрлийн зарим хэсэг нь асахгүй,
- Хийдийн 4 талаас тусах лед прожектор нь ажлын даалгаврын хүчин чадалд хүрэхгүй, газарт суурилуулаагүй,
- Тусгай суваргын гэрэлтүүлэг 3 ширхэг дутуу хийгдсэн,
- Хийдийн дотор гэрэлтүүлэг 7 ширхэг дутуу хийгдсэн ,

- Суурилуулсан 3 ширхэг хяналтын камерт холболт хийгээгүй,
- Тоо хэмжээнд туссан 2 ширхэг салхин сэнс хийгдээгүй

Зураг 3: Дэмчигийн хийд, Нарны сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй гэрэлтүүлэг



Уг ажлын гэрээний хугацаа 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр дууссан ба хил хааснаас бараа материал татан авах ажил удааширч гэрээний хугацааг 2022 оны 02 дугаар сарын 25-н хүртэл сунгасан байна. Улмаар хүлээж авах улсын комисс 2022 оны 07 дугаар сарын 22-нд ажилласан ба үүрэг даалгаврын биелэлт хийгдээгүй учир одоог хүртэл ашиглалтад хүлээж аваагүй байна.

2.4. Дээрх зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй байх, улсын комиссын өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй гүйцэтгэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар ажил зохион байгуулах тухай албан шаардлагыг аймгийн Засаг даргад өглөө.

2.5. Аялал жуулчлалын салбарт 2020-2022 онд 583.7 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын бус зардлын шинжтэй дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- “Аялал жуулчлал-Өрхийн орлого” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, эвент арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах ажлын хүрээнд Даланзадгад хоттой танилцах брошюр гаргахад 3027 ширхэг гарын авлага, палан зураг, брошюр хэвлүүлэхэд 44.4 сая төгрөг,
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх хэтийн зорилт, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх, орон нутгийн эвентүүд болон сургалт, зөвлөгөөн зохион байгуулахад 9.0 сая, Хямд амар аялал жуулчлалын цахим үзэсгэлэнд оролцоход 4.9 сая нийт 13.9 сая төгрөг,
- “Говийн гайхамшигт зургаа” уулзалт арга хэмжээ зөвлөгөөн зохион байгуулахад 22.5 сая, Говь гурван сайхан ууланд буга нутагшуулах ажилд 67.2 сая нийт 89.7 сая төгрөг,
- Өмнөговь аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хэтийн зорилт, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, орон нутгийн эвентүүдийг хөгжүүлэх, аялал жуулчлалын үзэсгэлэн, уулзалт, зөвлөгөөн, сургалтад оролцох, зохион байгуулахад 268.3 сая төгрөг,
- Түүх соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, олон нийтэд сурталчлан таниулах, сургалт танин мэдэхүйн ажлуудыг зохион байгуулахад 159.4 сая төгрөг,
- Сэврэй сумын аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд 8.0 сая төгрөг

2.6. Дээрх төсөл хөтөлбөр, эвент арга хэмжээ, үзэсгэлэн, сургалт, зөвлөгөөн зохион байгуулах ажлуудын үр өгөөж, эдийн засагт үзүүлсэн нөлөө зэргийн тооцоо судалгаа байхгүй байна.

2.7. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд гүйцэтгэсэн Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийг аялал жуулчлалтай хослуулан хамгаалах ажил нь Өмнөговь аймагт аялал жуулчлалын шинэ маршрут зүүн бүс нутагт хөгжих, Палеонтологийн-аялал жуулчлал хослуулан хөгжихөд түлхэц болох улмаар аялал жуулчлалын салбарын эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой хөрөнгө оруулалт болсон байна.

Зураг 4: Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийг аялал жуулчлалтай хослуулан хамгаалах ажил



2.8. Хээрийн лаборатори-музейн барилга баригдсанаар 2021 оны 7 дугаар сарын 31-ээс 2023 оны 10 дугаар сарын 1-ний хооронд 356 дотоод болон гадаадын аялагчид үйлчлүүлсэн байна.

Б.3 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт хийгдээгүй байна.

3.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг ГХБХБГ, Хөгжил, хөрөнгө оруулалтын газар, БОАЖГ, сумдын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнууд хяналт хийж гүйцэтгэлийг баталгаажуулсан байна.

3.2. Захиалагчийн зүгээс үе шатны ажлыг тухай бүр хянаж илэрсэн зөрчил, өгсөн зөвлөмжийн талаар талбайн журналд тэмдэглэн хянаж, ажлын гүйцэтгэлийг актаар баталгаажуулсан байна.

3.3. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагаас үүрэг даалгавар өгч, алдаа зөрчлийг арилгуулах талаар ажиллаж байгаа боловч барилга байгууламжийг хүлээн авах комисс ажиллахад алдаа дутагдлууд илэрч, үүрэг даалгаврууд өгөгдөж байгаа, барилга байгууламжийн зүгшрүүлэлтийн хугацаанд материал болон гүйцэтгэлийн чанараас шалтгаалсан доголдлууд гарч байгаа нь хяналт зохих үр дүнд хүрэхгүй байгааг харуулж байна.

3.4. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт болох Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020-2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, гүйцэтгэлийн байдалд хүний нөөц дутмаг, мэргэжлийн боловсон хүчин байхгүй шалтгаанаар хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж өгөөгүй байна.

3.4.1. Энэ нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1⁵ дахь заалттай нийцэхгүй байна.

3.5. Зөрчил дутагдлыг зөвхөн аудитаар илрүүлэх бус захиалагчийн зүгээс дотоод хяналт шалгалтыг төсөл, арга хэмжээ бүрийн гүйцэтгэл, хэрэгжилт, ашиглалтын байдалд хийж алдаа зөрчлийг илрүүлэн, шуурхай арилгаж ажиллах шаардлагатай байна.

Б.4 Төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, бүртгэлийг сайжруулах шаардлагатай байна.

4.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй хэрэгжүүлсэн Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийг аялал жуулчлалтай хослуулан хамгаалах ажлын хээрийн лаборатори-музейн барилгын зургийн даалгаварт орсон зарим ажил хийгээгүй байхад байнгын ашиглалтад оруулах улсын комисс 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн У-2022/33 дугаартай улсын комиссын дүгнэлтээр хүлээж авахдаа үүрэг даалгавар өгөөгүй байна.

4.2. Байгаль орчныг хамгаалах чиглэлийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хийсэн Дэмчигийн хийдийг нарны сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт холбох 60.9 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг хүлээж авах улсын комисс гүйцэтгэгчид үүрэг даалгавар өгсөн боловч биелэлтийг дахин хянаагүй байна.

4.3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн зарим хөрөнгө оруулалт ашиглалтын явцад чанарын шаардлага хангахгүй, эзэмшигч байгууллага хөрөнгийг бүртгэлд тусгаагүй зэрэг нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Хүснэгт 5: ТАХ-г хөрөнгөд бүртгэсэн байдал

Байгууллага	Нийт бүртгэлд авах ТАХ-ий тоо	Бүртгэлд авсан ТАХ-ий тоо				Бүртгэлд аваагүй ТАХ-ий тоо
		Барилга байгууламж	Их засвар	Тоног төхөөрөмж	ТЭЗҮ	
АЗДТГ	6	-	-	-	6	-
ОНӨГ	4	2	-	1		1
Сумдын ЗДТГ	5	2	-	1	1	1
Бусад байгууллага	2	2	-			-
нийт	17	6	-	2	7	2

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

4.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хийсэн Өмнөговь аймгийн аялал жуулчлалын бүс, байгаль, түүх соёлын өв бүхий Хонгорын голын Дуут манханд отоглох цэг байгуулах 98.6 сая төгрөгийн ажлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэр гараагүйгээс өмчийн бүртгэл хийгдээгүй хэвээр байна.

4.5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд ашиглалтад орсон 705.6 сая төгрөгийн өртөг бүхий Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийг аялал жуулчлалтай хослуулан хамгаалах ажлыг мөн бүртгэлд тусгагдаагүй байна.

4.6. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.4⁶ -т заасантай нийцэхгүй байна.

4.7. Дээрх зөрчлийг арилгуулах тухай албан шаардлагыг Орон нутгийн өмчийн газарт хүргүүлээ.

⁵ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”

⁶ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ

ДҮГНЭЛТ Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төсөл арга хэмжээ урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.
- Аялал жуулчлалын салбарт хийсэн хөрөнгө оруулалт сүүлийн 3 жилийн байдлаар голлох салбаруудтай харьцуулахад 2-13 дахин бага байна.
- Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний үр дүн, үр өгөөжийг тооцдоггүй байна.
- Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан байна.
- Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт хийгээгүй байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн 705.6 сая төгрөгийн өртөг бүхий Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийг аялал жуулчлалтай хослуулан хамгаалах ажлыг бүртгэлд тусгагдаагүй байна.
- Хээрийн лаборатори-музейн барилга баригдсанаар 2021 оны 7 дугаар сарын 31-ээс 2023 оны 10 дугаар сарын 1-ний хооронд 356 дотоод болон гадаадын аялагчид үйлчлүүлсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-ын дарга Н.Энхбат танаа

- Өмнөговь аймгийг хөгжүүлэх тэргүүлэх салбар болгон тодорхойлсон аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, эдийн засгийн олон эх үүсвэр бий болгоход анхаарч ажиллах.

Аймгийн Засаг дарга Р.Сэддорж танаа

- Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/10 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн аялал, жуулчлалыг хөгжүүлэх хэтийн зорилго, төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардлагатай менежментийн төлөвлөгөөнүүдийг шат дараатай боловсруулан, шаардагдах хөрөнгийг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан тайлагнаж байх,
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт, шалгалтыг төсөл, арга хэмжээ бүрийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, ашиглалтын байдалд хийж, үр дүнг тооцож байх,
- Барилга байгууламжийн ажлыг ашиглалтад оруулах улсын комисст томилогдсон нийтийн албан тушаалтнуудыг хууль, дүрэм журмыг мөрдөж ажиллах, хариуцлагатай байх талаар ажил зохион байгуулах;

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 204 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 70532849, Факс: (976) 70532111
Цахим шуудан: info@omnogovi.gov.mn
Цахим хуудас: www.omnogovi.gov.mn

2023. 10. 26 № 05/3339

танай _____ -ны № _____ -т

Тайлбар санал хүргүүлэх тухай

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Өмнөговь аймгийн аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалт, хэрэгжилтийн үр дүнд гүйцэтгэлийн аудит хийсэн тайлан, түүний дүгнэлт, зөвлөмжтэй танилцлаа.

2020-2022 онд дэлхий нийтийг хамарсан “Ковид-19” цар тахлын улмаас олон улсын хийл, гааль хаагдаж аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа доголдсон, мөн түүнчлэн бүтээн байгуулалтын ажил бараа материалын татан авалт, түүний тээврийн хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор тус салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажилд зөрчил детагдал гарсан ба түүнийг арилгах болон бусад зөрчлийг гаргасан шийдвэрийн дагуу шуурхай зохин байгуулж ажиллана.

Тус ажилд аудитаар илэрсэн алдаа зөрчил, тэдгээр гаргасан шийдэлд гаргасан тайлбар, тайланг зөрчлийн бүртгэлийн маягтын дагуу гарган хүргүүлж байна.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЙТСИЙН
ДАРГА О.ЭРДЭНЭ-ӨРНӨХ



Data D:/zdtg2023/A4.TD.doc

4623074204

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/22

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ийн 18.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Аудитын тайланг Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Байгаль орчин аялал жуулчлалын газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Р.Сэддорж)-д зөвлөсүгэй.
4. Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Т.Хонгорзул)-д даалгасугай.
5. Аудитын ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Г.Шижирболд)-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

01601004